



## GS1 СИСТЕМ, ЗУРААСАН КОД ОЛГОХ, “GS1 MONGOLIA” ТББ-ЫН ХЭРЭГЛЭГЧ ГИШҮҮНЭЭР БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1 “GS1 Mongolia” ТББ-ын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд GS1 систем, зураасан код (GS1-8, GS1-13, GS1/ITF-14, GS1-128, Datamatrix, Databar, QR гэх мэт стандартууд багтана) олгож хэрэглэгч гишүүнээр бүртгэх, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2 Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд зураасан код олгох ажиллагааг Олон Улсын GS1 байгууллагаас олгосон эрх, гэрээний дагуу “GS1 Mongolia” гүйцэтгэнэ.

### Хоёр: “GS1 Mongolia”-ын хэрэглэгч гишүүнээр бүртгэх

- 2.1 “Гишүүн” гэж энэхүү журмын дагуу дараах стандартуудын зураасан код эсвэл аль нэг төрлийн зураасан кодыг авч хэрэглэгч гишүүнээр бүртгэгдсэн хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. (Салбар бүхий компаний хувьд салбар бүр нь тусдаа хуулийн этгээдийн бүртгэлийн дагуу гишүүнээр элсэж бүртгүүлнэ). Үүнд:
  - Худалдааны эд зүйлсийн глобал дугаар (ХЭЗГД) буюу Global Trade Item Number (GTIN)
  - Байршлын глобал дугаар буюу Global Location Number (GLN)
  - Тээвэрлэлтийн Серийн дугаар (ТСД) буюу Serial Shipping Container Code (SSCC)
  - Бусад стандартууд
- 2.2 Монгол улсад тус системийг дэмжин сурталчлах, хэрэглэх сонирхол бүхий бүх хувь хүн, хуулийн этгээдэд хэрэглэгч гишүүнээр бүртгүүлэх, бүртгэх нь нээлттэй байна.
- 2.3 Хэрэглэгч гишүүнээр бүртгүүлж бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ зураасан код авахаар хүсэлт гаргагч бүх хувь хүн, хуулийн этгээд энэ журмын **Хавсралт №1**-д заасан маягтын дагуу “GS1 Mongolia”-д өөрийнхөө болон бараа үйлчилгээнийхээ талаарх мэдээллийг үнэн зөв, гаргацтай бөглөж өгөх ба мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл гаргагч өөрөө хариуцна.
- 2.4 Хэрэглэгч гишүүнээр бүртгүүлэх хүсэлтэнд дор дурдсан баримт бичгийг хавсаргана.
  - A. *Байгууллагын танилцуулга,*
  - B. *Аж ахуй нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /хувь хүн бол иргэний үнэмлэх, ажлын байрны дүгнэлт, тухайн бүтээгдэхүүний шинэжилгээний бичиг/*,
  - C. *Зураасан код хариуцсан ажилтан (итгэмжлэгдсэн төлөөлөгч) томилсон тухай албан бичиг,*
  - D. *GS1 систем, зураасан код олгох, “GS1 Mongolia” ТББ-ын хэрэглэгч гишүүнээр бүртгэх журам”-тай танилцсан тухай албан бичиг,*
  - E. *Элсэлтийн хураамж төлсөн баримт.*

- 2.5 Энэхүү журмын 2.4-т заасан бичиг баримтыг бүрдүүлээгүй буюу дутуу бүрдүүлсэн тохиолдолд хүслэтийг хүлээн авахгүй.
- 2.6 Системийн хэрэглэгч гишүүн болохоор хүсэлт гаргаж буй хувь хүн, хуулийн этгээд Худалдааны эд зүйлсийн глобал дугаар (ХЭЗГД) буюу Global Trade Item Number (GTIN) авахаар бол **Хавсралт №2**-д заасны дагуу элсэлтийн хураамж төлнө.
- 2.7 Худалдааны эд зүйлсийн глобал дугаар (ХЭЗГД) буюу Global Trade Item Number (GTIN) авсан хэрэглэгч гишүүний татварыг **Хавсралт №3**-д заасны дагуу төлнө.
- 2.8 Харин Байршлын Глобал Дугаар (БГД) буюу Global Location Number (GLN) болон Тээвэрлэлтийн Серийн Дугаар (ТСД) буюу Serial Shipping Container Code (SSCC) авсан хэрэглэгч гишүүн **Хавсралт №4**-д заасны дагуу элсэлтийн хураамж болон зураасан кодны сунгалтын төлбөрийг төлнө.
- 2.9 Элсэлтийн хураамж төлж системийн хэрэглэгч болсон хувь хүн, хуулийн этгээд нь GS1 системийн талаарх шинэ соргог мэдээлэл, танилцуулга, ном хэвлэлтийг үнэгүй ашиглах эрхтэй.
- 2.10 Системийн хэрэглэгч гишүүн нь “GS1 Mongolia”-ын бүх дүрэм журам, стандарт зохицуулалтыг дагаж мөрдөнө.
- 2.11 Системийн хэрэглэгч гишүүн болсон хувь хүн, хуулийн этгээд нь жил бүр зураасан кодны сунгалтын төлбөрийг төлнө. Гэхдээ хэрэглэгч гишүүнээр бүртгүүлсэн эхний жилдээ сунгалтын төлбөр төлөхгүй.
- 2.12 Зураасан кодны сунгалтын төлбөр, хураамжийн хэмжээг “GS1 Mongolia”-ын Удирдах зөвлөл тогтоох ба шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 2.13 Хэрэглэгч гишүүний эрх нь зөвхөн түүнд хамаарах ба өөрийн санаачлагаар бусдад үл шилжүүлнэ.

#### **Гурав: Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд GS1 систем, зураасан код олгох**

- 3.1 Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд зураасан код авахыг хүссэн хувь хүн, хуулийн этгээд нь зураасан код авах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг нэр, төрөл тус бүрээр гарган **Хавсралт №5**-т заасан маягтын дагуу бөглөсөн өргөдлийг цаасаар эсвэл цахимаар “GS1 Mongolia”-д гаргана. Өргөдлийг үнэн зөв, гаргацтай бөглөх ба өргөдөл дурдсан мэдээллийн үнэн зөвийг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.
- 3.2 Хэрэглэгч гишүүнээр бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээдийн гаргаж өгсөн аливаа мэдээлэл нь GS1 Mongolia-ын хэрэглэгч гишүүний бүртгэлийн мэдээллийн санд хадгалагдаж, GS1 олон улсын байгууллагын цахим бүртгэлийн нэгдсэн системд илгээгдэх болно.
- 3.3 Байршлын Глобал Дугаар (БГД) буюу Global Location Number (GLN) авах өргөдлийг **Хавсралт №6**, Тээвэрлэлтийн Серийн Дугаар (ТСД) буюу Serial Shipping Container Code (SSCC) авах өргөдлийг **Хавсралт №7**-д заасны дагуу цаасаар эсвэл цахимаар тус тус бөглөж өгнө.
- 3.4 GS1 систем, зураасан кодыг зөвхөн тухайн компаниас итгэмжлэгдэн томилогдсон төлөөлөгчөөр дамжуулан бичгээр эсвэл цахимаар гаргасан хүсэлтийн үндсэн дээр олгоно.
- 3.5 “GS1 Mongolia” нь зураасан код авах тухай хүсэлт, энэ журмын 2.4 болон 3.4-т заасан холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 1-2 хоногт багтаан зураасан код олгоно.



- 3.6 Зураасан кодыг олон улсын жишигийн дагуу зориулалтаар хэрэглэх ба бусдад шилжүүлэх, худалдахыг хориглоно.

**Дөрөв: Хэрэглэгч гишүүний бүртгэлээс хасах, зураасан кодыг хүчингүй болгох**

- 4.1 Хэрэглэгч гишүүн нас барсан буюу албан ёсоор татан буугдсан тохиолдолд түүний нэрийг хэрэглэгчийн гишүүний бүртгэлээс хасна.
- 4.2 Хэрэглэгч гишүүн тухайн жилийнхээ сунгалтын төлбөр, хураамжаа төлж барагдуулсан тохиолдолд нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнд үндсэн дээр хэрэглэгчийн гишүүний бүртгэлээс сайн дураараа гарч болно. Гэвч ийнхүү гараждаа аль ч хугацаанд төлсөн татвар, хураамж эсвэл төлбөрөө буцаан авах эрхгүй байна.
- 4.3 Хэрэглэгч гишүүн зураасан кодны сунгалтын төлбөр, хураамжаа нэг жил төлөөгүй бол гишүүний эрхийг цуцалж, нэрийг нь бүртгэлээс хасна. Гэвч үүнийг үл харгалзан түүний нэрийг хасах үед төлөөгүй байсан төлбөр, хураамжийг хүүгийн хамт төлөх үүрэгтэй хэвээр байна.
- 4.4 Хэрэглэгч гишүүн энэ журмын 2.11, 3.4 дугаар зүйлийг зөрчсөн нь батлагдвал уг кодыг хүчингүй болгож хэрэглэгч гишүүний эрхийг 3 жилийн хугацаатайгаар хасна.

**Тав: Бусад зүйл**

- 5.1 Зураасан код олгохтой холбогдсон гомдлыг “GS1 Mongolia”-ын удирдлагад гаргана. Түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх эрхтэй.
- 5.2 Зураасан кодыг зориулалтын дагуу хэрэглээгүй, бусдад шилжүүлсэн, худалдсан, зураасан код олгох үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

oooo00000oooo





GS1 систем, зураасан код олгох,  
“GST Mongolia” ТББ-ын хэрэглэгч гишүүнээр  
бүртгэх журмын Хавсралт №2

Элсэлтийн хураамжийн хувь хэмжээ нь “GS1 Mongolia”-аас тухайн хэрэглэгч гишүүнд олгосон  
“компанийн дугаар” буюу Худалдааны эд зүйлсийн глобал дугаар (ХЭЗГД) (англиар Global Trade  
Item Number товchoor GTIN)-аас хамаарна.

| Компанийн дугаар     | Бүтээгдэхүүний нэгжийн тоо /хамгийн их/ | Элсэлтийн хураамж /НӨАТ-тэй, төг/ |
|----------------------|---|-----------------------------------|
| 6 оронтой 865MMM     | 999 999 хүртэл                          | 3 950 000                         |
| 7 оронтой 865MMMM    | 99999 хүртэл                            | 1 550 000                         |
| 8 оронтой 865MMMMM   | 9999 хүртэл                             | 950 000                           |
| 9 оронтой 865MMMMMM  | 999 хүртэл                              | 550 000                           |
| 10 оронтой 865MMMMMM | 99 хүртэл                               | 450 000                           |
| 11 оронтой 865MMMMMM | 9 хүртэл                                | 200 000                           |

GS1 систем, зураасан код олгох,  
“GST Mongolia” ТББ-ын хэрэглэгч гишүүнээр  
бүртгэх журмын Хавсралт №3

| Компанийн дугаар     | Бүтээгдэхүүний нэгжийн тоо /хамгийн их/ | Хэрэглэгч гишүүний татвар/зураасан кодны сунгалтын төлбөр / НӨАТ-тэй, төг/ |
|----------------------|---|--|
| 6 оронтой 865MMM     | 999 999 хүртэл                          | 3 300 000  |
| 7 оронтой 865MMMM    | 99999 хүртэл                            | 1100 000   |
| 8 оронтой 865MMMMM   | 9999 хүртэл                             | 660 000  |
| 9 оронтой 865MMMMMM  | 999 хүртэл                              | 330 000  |
| 10 оронтой 865MMMMMM | 99 хүртэл                               | 220 000  |
| 11 оронтой 865MMMMMM | 9 хүртэл                                | 110 000  |

GS1 систем, зураасан код олгох,  
“GST Mongolia” ТББ-ын хэрэглэгч гишүүнээр  
бүртгэх журмын Хавсралт №4

| Нэр, төрөл  | Элсэлтийн хураамж /төгрөгөөр/ | Сунгалтын төлбөр / НӨАТ-тэй, төг/ |
|---|-------------------------------|-----------------------------------|
| Байршилын Глобал Дугаар (БГД) буюу<br>Global Location Number (GLN)              | 275 000                       | 220 000                           |
| Тээвэрлэлтийн Серийн Дугаар (ТСД) буюу Serial<br>Shipping Container Code (SSCC) |                               |                                   |